

## ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛЫН ТӨСӨЛ

### Журам, маягтын загвар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жолоочийн эрүүл мэндэд үзлэг хийх журмыг нэгдүгээр, тээврийн хэрэгсэлд байх анхны тусламжийн эмийн сангийн иж бүрдэл, тээврийн хэрэгсэл жолоодох үед хэрэглэхийг хориглох эм, бэлдмэлийн жагсаалтыг хоёрдугаар, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журмыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалаар батлагдсан журмыг мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллахыг төр, хувийн хэвшлийн бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд мэргэжил аргазүйгээр хангахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар /М.Наранпүрэв/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын азар /Б.Янжмаа/-т тус тус даалгасугай.

САЙД

Э.БАТШУГАР

## **Жолоочийн эрүүл мэндэд үзлэг хийх журам**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр механикжсан тээврийн хэрэгслийн жолоочийн эрүүл мэндэд үзлэгт хамруулах үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.1. Жолоочийн эрүүл мэндийн үзлэгийг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв болон Монгол Улсад ашиглах эмнэлэгийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээгээр баталгаажсан жолоочийн эрүүл мэндийн үзлэгийн цахим төхөөрөмжтэй тээврийн хэрэгсэл жолооч хэрэгсэл тээврийн хэрэгсэл жолооч бэлтгэх сургалтын байгууллага (авто сургууль, курс) зохион байгуулна.

1.2. Жолоочийн эрүүл мэндийн үзлэг нь иргэнийг тээврийн хэрэгсэл жолоодоход тэнцэх, эсэхийг тодорхойлно.

1.3. Эрүүл мэндийн үзлэгийг биечлэн эсхүл цахим төхөөрөмжөөр хийж тээврийн хэрэгсэл жолоодоход “тэнцэнэ” гэсэн эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт /цаашид “эрүүл мэндийн үзлэгийн хуудас” гэх/ -ыг баталгаажуулж өгнө.

1.4. Жолоочийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ нь дараах үзлэг, шинжилгээнээс бүрдэнэ. Үүнд: Нүдний хараа, өнгө ялгах чадвар, сонсгол, дотор, мэдрэл, сэтгэц, гэмтэл согог, мэс засал, хөгжлийн бэрхшээл /тулгуур эрхтний/, цусны бүлэг зэрэг болно.

1.5. Нийтийн тээврийн хэрэгслийн жолооч, хүнд оврын тээврийн хэрэгслийн жолоочид эрүүл мэндийн тусгай нөхцөл шаардаж болно.

1.6. Механикжсан тээврийн хэрэгсэл жолоодох эрх бүхий, замын хөдөлгөөнд оролцож буй жолооч жолоо барих эрхээ сунгах, сэргээлгэх бүрд эрүүл мэндийн үзлэгт орно.

1.7. Жолооч нь өнгө ялгах чадвар, сонсгол, хөгжлийн бэрхшээл /тулгуур эрхтний/-ийн үзлэгээс гарсан дүгнэлтийг үндэслэн шаардагдах таних тэмдгийг ашиглах /Тээврийн цагдаагийн албанаас олгох/

1.8. Жолооч тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийг зайлшгүй машиндаа байлгах, тогтмол баяжуулалт хийж, хүчинтэй хугацааг шалгаж байна.

### **Хоёр.Жолоочийн эрүүл мэндэд тавигдах үндсэн шаардлага**

2.1. Эрүүл мэндийн үзлэгт орох иргэн нь дор дурдсан нөхцөлийг хангасан байна:

2.1.1. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан тухайн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох эрх бүхий насанд хүрсэн;

- 2.1.2. иргэний үнэмлэх буюу түүнтэй адилтгах баримт бичигтэй;
- 2.2. Эрүүл мэндийн үзлэгт дараах хугацаанд хамрагдана.
  - 2.2.1. А, М, В ангиллын тээврийн хэрэгслийн жолооч жолоодох эрхийн үнэмлэхийн хугацаа дуусгавар болж сунгуулахад;
  - 2.2.2. С, D ангиллын болон нийтийн зорчигч тээвэр такси үйлчилгээний тээврийн хэрэгслийн жолооч 2 жил тутам;
  - 2.2.3. жолооч тухайн ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох шалгалтад ороход;
  - 2.2.4. тээврийн хэрэгслийн жолоодох эрхийг хассан хугацаа дуусгавар болж жолоодох эрхийн үнэмлэх авахад;
  - 2.2.5. жолоочийн зөрчлийг шалган шийдвэрлэх үед эрх бүхий байгууллагаас гаргасан хүсэлтийг үндэслэн үзлэгт хамрагдаж эрүүл мэндийн дүгнэлтийн хуудас авна.
- 2.3. Тээврийн хэрэгсэл жолоодоход “тэнцэнэ” гэсэн дүгнэлт гаргахад дараах эрүүл мэндийн шаардлага тавигдана.
  - 2.3.1. улаан, ногоон өнгө ялгах, сонсгол хэвийн (сонсголын төхөөрөмжтэй стандартад хүрч сонсож чаддаг), бүтэн бие, хүзүү, нуруу, зүрх судас (цахилгаан төхөөрөмжгүй)-ны үйл ажиллагааны алдагдал байхгүй;
  - 2.3.2. биеийн дээд мөчний хоёр гар бүтэн, гарны эрхий хуруутай байх, гар тус бүрийн гурван хуруу нь эрүүл, гар сарвууны хөдөлгөөний булчин шөрмөсний үйл ажиллагаа хэвийн байх ( );
  - 2.3.3. биеийн доод мөчүүд нь эрүүл, хэвийн байх (хөлийн сарвуу тулгуур эрхтний зүүн мөч байхгүй булчин шөрмөсний үйл ажиллагаа алдагдсан бол механик хурдын хайрцагтай тээврийн хэрэгсэл барих боломжгүй);
  - 2.3.4. харааны бэрхшээлтэй хүмүүс жолоодлогын аюулгүй байдлыг хангахын тулд хэвийн хараатай байх;
    - 2.3.4.1. хоёр нүдний хүүхэн хараа эсвэл тэглүүлсэн хараа нь логарифмын харааны график (хараа зүйн түвшин тогтоодог самбар) дээр 4.9-5.0 ба түүнээс дээш байх; (харааны шилтэй бол хэрхэх)
    - 2.3.4.2. улаан, ногоон өнгө ялгах чадвартай, нэг нүд сохор бол логарифмын харааны графикт ..... дээш байх;
  - 2.3.5. хоёр чих бүр болон сонсголын хооронд 50 см зайд дууны эх үүсвэрийн чиглэлийг нарийн тодорхойлох чадвартай байх. Сонсголын бэрхшээлтэй ч сонсголын төхөөрөмж зүүснээр энэ нөхцөл хангагдах боломжтой бол суудлын автомашин барих боломжтой.
  - 2.3.6. их бие, хүзүүнд хөдөлгөөнийг хязгаарласан төхөөрөмж суулгасан, үйл ажиллагааны доголдол байхгүй эсэхийг баталгаажуулах;

2.3.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэн баруун доод мөч эсвэл хоёр доод мөчний хөдөлгөөний дутагдалтай, эсхүл алдсан боловч бие даан сууж, зогсож чаддаг дээд мөч нь тодорхой нөхцөлийг хангасан бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тоногдсон автомат хурдны хайрцагтай суудлын автомашины жолооны үнэмлэх авах хүсэлт гаргаж болно. (Нэг гар дутуу, нөгөө гарын эрхий хуруу, хоёроос доошгүй хуруу нь бүрэн, дээд мөч болон хурууны хөдөлгөөний үйл ажиллагаа хэвийн, доод мөч нь энэ журмын шаардлагад нийцсэн бол энэ төрлийн жолооны үнэмлэх авах нөхцөлийг хангасан гэж үзнэ).

### **Хоёр. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг**

- 2.4. Эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг холбогдох, стандарт, удирдамж, журам, зааврын дагуу үнэн зөв хийж, шуурхай үйлчилнэ.
- 2.5. Үзлэг, шинжилгээний онош, дүгнэлтийг үзлэг хийсэн эмч, эмнэлгийн эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулахаас гадна гарын үсэг болон жолоочийн зурган дээр эрүүл мэндийн байгууллагын дардасыг заавал дарсан байна.
- 2.6. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь эрүүл мэндийн дүгнэлт гаргахдаа “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ”-г чанд мөрдөж ажиллана.
- 2.7. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг батлагдсан маягт дээр үйлдэнэ.
- 2.8. Цусны бүлгийг батлагдсан стандарт, аргачлалын дагуу тодорхойлж, дардас дарж тэмдэглэгээ хийж гарын үсэг зурна.
- 2.9. Үзлэг, шинжилгээ хийсэн тайланг хагас, бүтэн жилээр гаргана.
- 2.10. Жолоочийн эрүүл мэндийн үзлэгт орох иргэнд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан маягтын дагуу үзлэгийн хуудсыг олгож үзлэгт илгээнэ.

### **Гурав. Жолоочийн эрүүл мэндийн үзлэг хийх байгууллагын эрх, үүрэг**

- 3.1. Жолоочийн эрүүл мэндийн үзлэг хийх байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
  - 3.1.1. Эрүүл мэндийн цахим сангаар дамжуулан иргэний мэдээллийг хүлээн авч эмчийн үзлэг хийх;
  - 3.1.2. Үзлэг, шинжилгээний онош, дүгнэлтийг үзлэг хийсэн эмч, эмнэлгийн эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулахаас гадна гарын үсэг болон жолоочийн зурган дээр эрүүл мэндийн байгууллагын дардасыг заавал дарж баталгаажуулах;
  - 3.1.3. Эрүүл мэндийн цахим санд байгаа иргэний өвчний мэдээллийг энэ журмын шаардлагад нийцэх эсэхийг шалгаж, үзлэгийн мэдээлэлд тулгуурлан дүгнэлтийг цахимаар гаргах, цахим дүгнэлтэд 3.1.2 дахь заалт хамаарахгүй;

- 3.1.4. Цахим дүгнэлтийг “Эрүүл мэндийн дүгнэлтийн хуудас”-ыг Emongolia цахим системээс ажлын 3 хоногийн дотор илгээх
- 3.1.5. Эмнэлэгийн үзлэгт хамрагдах ёстой эмнэлэгийн мэргэжилтнүүдийн үзлэг, шинжилгээний жагсаалт, байгажийн болон лабораторын шинжилгээ хийж болзошгүй байдлын талаар үзлэгт хамрагдаж буй иргэнд ойлгомжтой танилцуулах.

#### **Дөрөв. Эрүүл мэндийн үзлэгийн төрөл, агуулга, цахим төхөөрөмжийг ашиглах**

- 4.1. Жолоочийн эрүүл мэндийн үзлэг нь биечилсэн, цахим төхөөрөмжийн гэсэн хоёр төрөлтэй байна.
- 4.2. Биечилсэн үзлэгээр жолооч болох иргэний эрүүл мэндийг энэ журамд заасан шаардлагыг баримтлан нарийн мэргэжлийн эмч нар хийж, дүгнэлтийг мэдээллийн санд оруулна.
- 4.3. Цахим төхөөрөмжийн үзлэгээр жолооч болох иргэний эрүүл мэндийг ухаалаг системийн тусламжтай хийж, энэ журмын шаардлага хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргана.
- 4.4. Цахим төхөөрөмж нь иргэний эрүүл мэндийн цахим мэдээллийн сантай холбогдсон байх бөгөөд энэ журмын шаардлага хангахгүй тохиолдолд дүгнэлт гаргах боломжгүйгээр тохируулагдсан байна.
- 4.5. Иргэн цахим төхөөрөмжөөс өгч байгаа мэдээллийн дагуу өөрийн мэдээллийг оруулж, өгсөн даалгаврыг биелүүлэх замаар үзлэгт хамрагдах ба бусдын дэмжлэгийг авах боломжгүйгээр тохируулагдсан байна.
- 4.6. Эрүүл мэндийн үзлэгийн цахим төхөөрөмж нь Монгол Улсад ашиглах эмнэлэгийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээгээр баталгаажсан байна.

Эрүүл мэндийн сайдын ..... оны  
 ..... дугаар сарын .....-ны өдрийн ..... дугаар  
 тушаалын хоёрдугаар хавсралт

**Нэг. Тээврийн хэрэгсэлд байх анхны тусламжийн эмийн сангийн иж бүрдэл**

№	Эм, эмнэлгийн хэрэгслийн нэр	Савалгаа	Тоо хэмжээ	Хэрэглэх заалт
1	Анхны тусламжийн иж бүрдэл /30*20*15 см-ээс багагүй/	Хайрцаг нь эмнэлгийн таних тэмдэгтэй байна.	1	
2	Ибупрофен 0,4 эсвэл 0,5 №10	боодол	1	Өвдөлт намдаах, халуун бууруулах
3	Нитроглицерин 0,15 мг	боодол	1	Зүрхний өвдөлт намдаах
4	Долоогоны ханд 100 мл	флакон	1	Зүрхний өвдөлт намдаах
5	Идэвхижүүлсэн нүүрс 0,5 № 20	боодол	1	Хордсон үед
6	Шингэн сэлбэх давс /ORS/ нунтаг 250 гр	боодол	2	Суулгалт, бөөлжилт, хордлогын үед
7	Иодын спиртэн уусмал 5%-20 мл	флакон	1	Шарх ариутгах
8	Аспирин 0,5 №10	боодол	1	Өвдөлт намдаах, халуун бууруулах
9	Денутарат спирт 20 мл	флакон	1	Ариутгал, халдваргүйтгэл хийх
10	Судас дарагч чангалуур	ширхэг	1	Цус тогтоох
11	Ариутгаагүй самбай боолт 10 см*5 м	боодол	1	Шарх боох
12	Уян бинт 10см*2 м	боодол	1	Мэс заслын дараа болон бэртэл гэмтлийн үед боолт хийх
13	Ариутгаагүй хөвөн	боодол	1	Халдваргүйжүүлэлт, ерөнхий цэвэрлэгээ хийх шингээх чадвар сайтай
14	Чиг баригч	ширхэг	1	Гэмтсэн гар, хөлөнд чиг барина
15	Ариутгасан бээлий	хос	2	Гар бохирдох, халдварлагдахаас сэргийлэх
16	Хайч мохоо үзүүртэй /4*6 см урттай/	ширхэг	1	Гэмтсэн, бэртсэн үед хэрэглэх

18	Шархны наалт 2,5см*1м урт	хайрцаг	1	Шархны халдвараас сэргийлэх
19	Амны хаалт	ширхэг	2	Халдвараас сэргийлэх
20	Түлэнхийд хэрэглэх тос, спрей	ширхэг	1-2	Түлэгдсэн үед анхны тусламжаар хэрэглэх

*Анхааруулга:*

*Анхны тусламжийн эмийн хайрцганд байх эм, эмнэлгийн хэрэгсэл нь үйлдвэрээс савласан савлагаа, боодолтой, хүчинтэй хугацаатай байна. Эм, эмнэлгийн хэрэгсэл тус бүрийн хэрэглэх зааврыг монгол хэл дээр бичиж хийсэн байна.*

### **Хоёр. Тээврийн хэрэгсэл жолоодох үед хэрэглэхийг хориглох эм, бэлдмэлийн жагсаалт**

1. Жолоо барих үед эмийг дур мэдэн хэрэглэж болохгүй бөгөөд эмчид хандаж эмчийн өгсөн зааврын дагуу эмийг хэрэглэнэ.

2. Эмийг хэрэглэхийн өмнө эмийн заавартай танилцаж тухайн эмийн үйлдэл, хориглох заалт, гаж нөлөөний талаар мэдээлэл авах, тухайн эмийг жолоо барих үед хэрэглэж болох эсэхийг эмчээс асууж тодруулах шаардлагатай.

3. Нойр хүргэх, орчноо мэдрэх хариу урвалыг бууруулах, хөдөлгөөний тэнцвэр алдагдуулах, толгой эргэх, анхаарал сулруулах, төв мэдрэлийн системийг дарангуйлах, нүдний хараа муутгах, мансууруулах үйлдэл үзүүлэх эмийг хэрэглэж болохгүй.

4. Жолооч эм хэрэглэх тохиолдолд эмийн заавар дээрх “Анхааруулга” хэсэгт тээврийн хэрэгсэл жолоодоход үзүүлэх нөлөөллийн талаарх мэдээллийг онцгой анхаарах.

Жолоо барих үед дараах эмийг хэрэглэхийг хориглоно. Үүнд:

- Харшлын эсрэг эм
- Мансууруулах эм
- Сэтгэцэд нөлөөт эм
- Нойрсуулах, тайвшруулах үйлдэлтэй эм
- Нойр хүргэх үйлдэлтэй бодис агуулсан ханиадны эм
- Транквилизаторууд
- Спирттэй ханд
- Вета блакатор
- Кодейн агуулсан бэлдмэл
- Суулгалтын эсрэг эм – ЦНС дарангуйлдаг
- Атропин агуулсан нүдний бэлдмэл
- Кофейн агуулсан эм – хөдөлгөөний тэнцвэр алдагдуулах эм
- Тайвшруулах, нойрсуулах бодис агуулсан биологийн нэмэлт бүтээгдэхүүн, ургамлын гаралтай бэлдмэл

### Гурав. Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага

Үзлэг	Шалгуур
Нүдний хараа /нүдний харааны засал хийлгэснийг оруулна/	<ul style="list-style-type: none"> <li>- А, В, С, Д үнэмлэхний хувьд 2 нүдийг нээлттэй байхад хэмжсэн хараа 0,8 эсвэл түүнээс сайн, нүд тус бүрийн хараа 0,5 эсвэл түүнээс сайн байх ёстой.</li> <li>- Хоёрдугаар ангиллын үнэмлэхний хувьд 2 нүдийг нээлттэй байхад хэмжсэн хараа 0,5 эсвэл түүнээс сайн байх ёстой бөгөөд жолооч зөвхөн 1 нүдээр харж чадах тохиолдолд харах боломжтой нүдний хараа 0,5 эсвэл түүнээс сайн байх ёстой.</li> </ul>
Өнгө ялгах чадвар	Улаан, ногоон, шар өнгийг ялгах чадвартай байх ёстой.
Сонсох чадвар	55 эсвэл түүнээс дээш децибелийн дуу чимээг сонсох чадвартай байх ёстой. Сонсголын аппарат ашигладаг бол 40 эсвэл түүнээс дээш децибелийн дуу чимээг сонсох чадвартай байх ёстой.
Мэдрэл, сэтгэц	<p>Сэтгэцийн эмчийн хяналтад байдаг эсэх лавлагаа авах</p> <ul style="list-style-type: none"> <li>- Уналт, таталт өгдөг</li> </ul>

Эрүүл мэндийн сайдын ..... оны  
..... дугаар сарын .....-ны өдрийн ..... дугаар  
тушаалын гуравдугаар хавсралт

## **Зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журам**

### **1. Нийтлэг үндэслэл**

1.1. Зам тээврийн осолд өртсөн хүнд яаралтай тусламж, (урьдчилсан үнэлгээ, анхан шатны тусламж) үзүүлэх, эмнэлэг хүртэл тээвэрлэхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Анхны тусламж нь аливаа осол гэмтэлд өртсөн хүний биеийн байдлыг цаашид улам хүндрүүлэхгүй байх, нэмж гэмтэл авахаас хамгаалах, амин чухал эрхтний үйл ажиллагааг сэргээх, хэвийн байдалд оруулахад чиглэнэ.

1.3. Анхан шатны тусламж үзүүлэгч гэж ослын газарт байгаа болон анх очсон иргэн, цагдаа, онцгой байдал, түргэн тусламжийн багийг хэлнэ.

1.4. Өөрийн болон бусдын аюулгүй бадлыг нэн тэргүүнд хангах, хохирогчийг дэмий хөдөлгөхгүй байх, түргэн тусламж дуудах, тээврийн хэрэгслийн ойр хавьд гал, дэлбэрэлт, утаа, шатахуун алдалт байгаа эсэхийг шалгах, мэргэжлийн бус хүн ослын газарт зөвхөн амь нас аварч болох үндсэн үйлдэл хийх ерөнхий зарчмыг баримтална.

### **2. Хохирогчийн газарт анх очсон хүний хийх үйлдэл**

2.1. Ослын газрын аюулыг үнэлэх, түргэн тусламж дуудах, амьлуулах суурь тусламжийг хугацаа алдалгүй үзүүлнэ.

2.2. Хохирогч ухаантай эсэх, амьсгал байгаа эсэхийг шалгаж, амьсгалгүй бол цээж шахалтыг хийж, амьсгалтай бол хажуу байрлалд оруулна(нуруу, хүзүү гэмтсэн сэжиггүй үед)

2.3. Түргэн тусламжийн баг ирэхэд хохирогчийн байдал, хийсэн тусламжийн талаар мэдээлэл өгнө.

2.4. Хугарсан ясыг зөв байрлуулах, ил гарсан эрхтэнийг дотогш түлхэх, толгой хүзүүг хүчээр хөдөлгөх, өвчтөнд уух юм өгөх, ам руу нь хуруугаа хийж бөглөөс авах оролдлого хийх, буруу байрлалд хүчээр суулах, зөөхийг хориглоно.

### **3. Эрүүл мэндийн болон бусад байгууллагын үүрэг**

3.1. Түргэн тусламжийн баг хохирогчийн биеийн байдлыг үнэлж, амьлуулах суурь тусламж болон лавшруулсан тусламжийг үзүүлж, түргэн тусламж, яаралтай тусламж, эмнэлэг хүртэлх тээвэрлэлтийн холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлэн ажиллана.

3.2. Эрүүл мэндийн байгууллага зам тээврийн осолд өртсөн иргэнд холбогдох хууль, журам, эмнэлэг хооронд шилжүүлэх зохицуулалтыг мөрдөн ажиллана.

3.3. Цагдаагийн байгууллага нь ослын газрыг хамгаалах, тээврийн хөдөлгөөнийг түр зохицуулах, түргэн тусламжийн багт зам чөлөөлөх, хохирогчийн аюулгүй байдлыг хангана.

3.4. Онцгой байдлын байгууллага нь хавчуулагдсан, машинд гацсан хүнийг харгах аврах үйл ажиллагааг зохион байгуулах, аюултай нөхцөл (гал, шатахуун алдалт)-ийг хянах, түргэн тусламжийн багтай уялдаатай ажиллана.

3.5. Жолооч бэлтгэх байгууллага нь тээврийн хэрэгсэлд байх анхны тусламжийн эмийн сангийн иж бүрдэлийн ашиглах заавар болон амилуулах суурь тусламжийг үзүүлэх сургалтыг мэргэжлийн байгуулалга, нийгэмлэг, холбоотын сургалтад хамруулах үйл ажиллагааг зохион байгуулна.

## ТАНИЦЛУУЛГА

### Нэг.Нөхцөл байдал, хэрэгцээ шаардлага

Швейцарын Женев хотноо 2021 оны 10 дугаар сард зохион байгуулсан хуралдаанаар дэлхийн улс орнуудын засгийн газрууд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас гаргасан тогтоолоор зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт, гэмтлийг 50-аас доошгүй хувиар бууруулах үндсэн зорилт бүхий Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны 10 жилийн /2021-2030 он/ төлөвлөгөөг баталсантай холбоотой зам тээврийн осол зөрчлөөс үүдэлтэй хүний амь, эрүүл мэнд, эд материалд учрах хохирлыг бууруулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсын хүн амын тоо 15.5 хувиар өссөн байна. 2015 онд 3,057,778 хүн амь бүртгэгдсэн бол 2024 оны судалгаагаар 3,546,700 хүн бүртгэгдэж, механикжсан тээврийн хэрэгслийн жолоочийн тоо сүүлийн 10 жилийн хугацаанд 39.8 хувиар өссөн.

Тээврийн хэрэгслийн тоо 45.6 хувиар тус тус өссөн байна. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 1,582,000 жолооч, 1,338,956 тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцож байна.

Зам тээврийн ослын тоо мэдээг сүүлийн 10 жилийн байдлаар харьцуулж үзэхэд 2015 онд 45,161 зам тээврийн осол бүртгэгдэж байсан бол 10 жилийн дараа 30,977 болж 31.4 хувиар буурсан байна. Гэвч графикайг үзвэл ковид-19 цар тахал гарсан үед 21,000 хүртэл буурч байсан боловч сүүлийн 5 жилийн хугацаанд тогтмол өсөлттэй байна.

Зам тээврийн ослын улмаас нас барсан хүний тоо мэдээлэл өнгөрсөн 2024 онд 631 бүртгэгдсэн сүүлийн 10 жилийн хугацаанд бүртгэгдсэн хамгийн өндөр тоо болж байна. Мөн өнгөрсөн онд 69 хүүхэд зам тээврийн осол улмаас амь хохирсон харамсалтай мэдээлэл гарсан байна.

Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүний тоо сүүлийн 10 жилийн хугацаанд үзвэл ковид-19 цар тахал гарсан хугацаад буурсан хэдий ч сүүлийн 3 жилийн тогтмол өсөж байна. Үүнээс гэмтсэн хүүхдийн тоо 2021 оноос хойш 2 дахин өссөн байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар дэлхий дээр өдөр 3500 хүний амь хохирч, жил бүр 1,3 сая хүний амь хохирч, 50 сая хүн гэмтэж бэртэж байсан гэсэн судалгаа байна. Цаашлаад ойрын 10 жилийн хугацаанд бага, дунд орлоготой орнуудад зам тээврийн ослын улмаас 13 сая хүний амь хохирч, 500 сая гэмтэх магадлалтай байна.

Манай орны хувьд зам тээврийн ослын улмаас өдөрт 1-2 хүний амь хохирч, сүүлийн 10 жилийн судалгаагаар 1 жилд дунджаар 517 хүний амь хохирч, 3946 хүн гэмтэж бэртсэн байна. Ойрын 10 жилийн хугацаанд энэ тоо өсөж жилд дунджаар 1000 хүний амь хохирч, 5000 дээш хүн гэмтэж бэртэх магадлалтай байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан

10.1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь дараах төрөлжсөн сангаас бүрдэнэ:

10.1.6.жолоочийн эрүүл мэнд, зам тээврийн осолд өртсөн хүний бүртгэл, мэдээллийн санд механикжсан тээврийн хэрэгслийн жолоочийн эрүүл мэндийн

үзлэгийн дүгнэлт, зам тээврийн ослын улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо бүртгэл, мэдээллийг хамруулах;

10.2.Энэ хуулийн ..., 10.1.6-д заасан санг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ..., тус тус хариуцан хөтөлнө. гэж заасан.

Мөн хуулийн 11 дүгээр зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ

11.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, хүний амь насыг аврахад чиглэсэн эмнэлгийн дараах тусламж, үйлчилгээг зохион байгуулж хэрэгжүүлнэ:

11.1.1.зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх талаар иргэнд чиглэсэн сургалт, сурталчилгааны хөтөлбөр хэрэгжүүлэх;

11.1.2.зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх;

11.1.3.зам тээврийн осолд өртсөн хүнд үзүүлэх эмнэлгийн байгууллагын яаралтай тусламж, үйлчилгээ, нөхөн сэргээх эмчилгээний чанар, шуурхай байдлыг хангах;

11.1.4.зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх эмнэлэг, анхны тусламжийн цэг, харьяалагдах нутаг дэвсгэрийг тодорхойлох, ажиллах нөхцөл, боломжоор хангах;

11.1.5.тээврийн хэрэгслийн жолооч болон жолооч бэлтгэх сургалтад хамрагдах иргэнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах.

11.2.Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн байгууллагын жагсаалт, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.3.Жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэх, зам тээврийн ослын улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо бүртгэх зааврыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

Дээрх нөхцөл байдал хууль эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг авч үзэхэд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа төдийгүй тус хуулийн 11.2 дах заалтын хэрэгжилт өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй байна.

Хоёр.Гадаад улсын туршлага

#### 1.Эрүүл мэндийн үзлэг хийх журмын талаар:

##### **Оросын Холбооны Улс:**

**Бүгд Найрамдах Хятад Ард Улс:** БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яамны 162 тоот тушаал "Авто тээврийн хэрэгслийн жолоочийн үнэмлэх хэрэглэх, хэрэглэх журам"-ыг 2021 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн яамны 8 дугаар хуралдаанаар хянан хэлэлцэн баталж, 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Энэ журамд жолоочийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүднээс жолооны үнэмлэх авахад шаардагдах биеийн нөхцөл байдалд тодорхой шаардлага тавьсан байна.

Хязгаарлалт хийх эмгэгүүд	АНУ	БНСУ	Япон	БНХАУ	Европийн холбоо
<p>1. Чихрийн шижин (инсулин эмчилгээ хийгддэг)</p>	<p>Эмчийн дүгнэлтээр зөвшөөрөл авна. Зарим мужид Бүлэг 2-ийн ангилалд зөвшөөрөл олгохгүй гэсэн заалттай.</p>	<p>Бүлэг 2 ангилалд зөвшөөрөх тохиолдол: хүнд хэлбэрийн гипогликемид орж байгаагүй буюу үүнийг нотлох эмчийн дүгнэлтийг 6 сар тутамд шаарддаг.</p>	<p>Гипогликемийн комад орж байсан тохиолдолд жолоодох эрхийг хязгаарлана.</p>	<p>Бүлэг 2 ангилалд жолоодох эрхийг хязгаарлана.</p>	<p>Бүлэг 2 ангилал: Жилд <math>\geq 2</math> удаа гипогликемийн комад орж байсан бол жолоодох эрхийг хязгаарлана.</p> <p>Бүлэг 1 ангилал: гликемийн хяналт сайн тохиолдолд зөвшөөрнө.</p>
<p>2. Эпилепси болон уналт таталт</p>	<p>6-12 сарын хугацаанд уналт, таталт тохиолдоогүй үед 2-10 жилийн хугацаагаар жолоодох эрх олгоно</p>	<p>2 жилийн хугацаанд уналт, таталт тохиолдоогүй үед эрх олгоно.</p> <p>Бүлэг 2 ангилалд жолоодох эрхийг хязгаарлана.</p>	<p>2 жилийн хугацаанд уналт, таталт тохиолдоогүй үед эрх олгох ба эмчийн дүгнэлт шаардлагатай.</p>	<p>2 жилийн хугацаанд уналт, таталт тохиолдоогүй үед эрх олгох ба эмчийн дүгнэлт шаардлагатай.</p>	<p>Бүлэг 1 ангилал: 1 жилийн хугацаанд уналт, таталт тохиолдоогүй байх</p> <p>Бүлэг 2: Эмийн эмчилгээгүйгээр сүүлийн 10 жилд уналт, таталт тохиолдоогүй үед эрх олгоно.</p>

3. Харааны бэрхшээл	Хамгийн багадаа засарсан харааны чадал 20/40 байх	Харааны чадал, талбайн босго оноог хангасан байх (хамгийн багадаа 120°).	Хамгийн багадаа 0.7  Бүлэг 2 ангилалд хамгийн багадаа 150°.	Хамгийн багадаа 0.8	Бүлэг 1 ангилал: харааны чадал 20/40 ба 120°–140°  Бүлэг 2 ангилалд хязгаарлана.
4. Танин мэдэхүйн бууралт (тэнэгрэл)	Муж бүрт ялгаатай. Ихэвчлэн дунд ба хүнд зэргийн танин мэдэхүйн бууралттай үед хязгаарлана.	Эмчийн магадлагаа шаардлагатай. Өдөр тутмын үйл ажиллагаа хязгаарлагдсан ан тэнэгрэлийн үед хязгаарлана.	Нас $\geq 75$ үед танин мэдэхүйн тест- сорилд тэнцсэн байхыг шаардана. Тэнэгрэл илэрсэн үед жолоодох эрхийг хязгаарлан а.	70 настай тохиолдо лд танин мэдэхүйн тест- сорилд тэнцсэн байхыг шаардан а. Тэнэгрэл илэрсэн үед жолоодо х эрхийг хязгаарл ана	Өдөр тутмын үйл ажиллагаа хязгаарлагдсан ан тэнэгрэлийн үед хязгаарлана. Дахин үнэлгээ шаардагдан а.
5. Нойрны эмгэгүүд	Хэрэв өдөр нойрмоглох эмгэгтэй хүмүүст эмчилгээ хангалтгүй гэж дүгнэсэн тохиолдолд жолоодох эрхийг хязгаарлана. Харин эмчилгээ хийгдсэн нойронд амьсгал тасалдах	Эмчилгээний үр дүнгээс хамаарах ба эмчийн дүгнэлт шаардлагатай.	Шаардалга тай тохиолдолд шинжилгээ, эмчийн дүгнэлтийг шаардана. Эмчилгээ үр дүнтэй байгаа тохиолдлуудад жолоодох эрхийг олгоно.	Нойронд амьсгал тасалдах эмгэгтэй хүмүүст эмчилгээ үр дүнтэй байгаа тохиолдо лд зөвшөөр өл өгнө. Бусад тохиолдо лд	Нойронд амьсгал тасалдах эмгэгтэй хүмүүст эмчилгээ үр дүнтэй байгаа тохиолдолд зөвшөөрөл өгнө. Хүнд хэлбэрийн нойрны эмгэгтэй тохиолдолд татгалзана.

	эмгэгтэй хүмүүст зөвшөөрөл өгнө.			татгалзана.	
8. Архины хамаарал	Эмчилгээ хийгдэж эмчлэгдсэн талаарх нотолгоо шаардлагатай . Автомашины аюулгүйн <b>сэрэмжлүүлэгч төхөөрөмж (interlock system)</b> ашиглаж болно. Зөрчил гаргавал хүчингүй болгох үндэслэл болно.	Архинд донтох эмгэгтэй тохиолдолд жолоодох эрхийг хязгаарлана. Эмчилгээ хийгдэж эмчлэгдсэн талаарх нотолгоо шаардлагатай.	Архинд донтох эмгэгтэй тохиолдолд жолоодох эрхийг хязгаарлана. Эмчилгээ хийгдэж эмчлэгдсэн талаарх нотолгоо – магадлагаа шаардлагатай.	Архинд донтох эмгэгтэй тохиолдолд жолоодох эрхийг 3-5 жилээр хязгаарлана.	Архинд донтох эмгэгтэй тохиолдолд жолоодох эрхийг хязгаарлана. Эмчилгээ хийгдэж эмчлэгдсэн талаарх нотолгоо – магадлагаа шаардлагатай. Автомашины аюулгүйн <b>сэрэмжлүүлэгч төхөөрөмж (interlock system)</b> ашиглаж болно.
7. Сэтгэцийн эмгэг	Солиорол, мания-донтох эмгэг, амиа хорлох эмгэгтэй байх нь жолооны эрхийг хязгаарлах үндэслэл болно. Эмчилгээ хийлгэсэн, тогтвортой байдалтай байгаа өвчтөнүүд	Эмчийн магадлагаа, тодорхойлолтыг үндэслэн жолоодох эрх олгоно. Эмчилгээ хийгдэж эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байсан тохиолдолд жолоодох эрхийг хязгаарлах	Сэтгэцийн эмгэгтэй тохиолдолд нэмэлт шинжилгээ, оношилгоо шаардагдана.	Хүнд хэлбэрийн сэтгэцийн эмгэгтэй = сэжигтэй тохиолдолд дахин шинжлэх, эмчийн магадлагаа	Хэрэв өвчтөнд ухаан санаа самуурах, зан төлөв өөрчлөгдсөн тогтвортой байдал алдагдсан бол жолоо барихыг зөвшөөрөхгүй. Харин тогтвортой байдалтай өвчтөнүүд

	жолоодох эрх олгож болно.	үндэслэл болно.		шаардлага гатай	жолооны үнэмлэх авах боломжтой.
8. Зүрх судасны эмгэг	Зүрхний шигдээсийн үед түр хугацаагаар жолоо барих эрхийг хасна (1–6 сарын хугацаанд). Энэ нь муж бүрт харилцан адилгүй байдаг.	Эмчийн магадлагаа шаардлагатай. Хэрэв өвчний байдал тогтворгүй бол жолоо барихыг хориглоно.	Ойрын хугацаанд зүрхний шигдээс (MI) эсвэл хүнд хэлбэрийн зүрхний хэм алдалт оношлогдсон үед жолооны эрхийг түдгэлзүүлнэ. Эмчилгээ хийсний дараа дахин үнэлгээ хийнэ.	Эмнэлгийн үзлэг, шинжилгээ заавал хийгдэнэ. Зүрх судасны эмгэгийн өндөр эрсдэлтэй тохиолдолд жолоо барих эрх олгохгүй.	Өвчний байдал тогтворжсоны дараа жолоо барихыг зөвшөөрнө. Бүлэг 2 ангилал: жолооч нарт илүү хатуу шаардлага тавигддаг: жишээлбэл, зүрхний шигдээсийн дараа 3–6 сарын хугацаанд эрхийг хязгаарлана.

## 2. Зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журам"-ын талаар:

**Бүгд Найрамдах Хятад Ард Улс:** Зам тээврийн осолд өртсөн хүнд яаралтай болон эмнэлгийн тусламж үзүүлэхтэй холбоотой тусгай хууль, журмаар зохицуулагддаг байна. Үүнд: “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-ийн 75-р зүйл: Эмнэлгийн байгууллагууд зам тээврийн осолд өртсөн хүмүүст тусламж үзүүлэхдээ төлбөрийн асуудлаас үл хамааран яаралтай тусламжийг саадгүй, цаг алдалгүй үзүүлэх үүрэгтэй гэж заасан байна. Мөн энэ хуульд зааснаар зам тээврийн ослын үед жолооч нь хохирогчийг анхны тусламж үзүүлэх, яаралтай түргэн тусламж дуудах, ослын газрыг орхихгүй байх үүрэгтэй. Түүнчлэн “Онцгой байдлын үед авах арга хэмжээний тухай хууль” нь аливаа гамшиг, ослын үед төрийн болон орон нутгийн байгууллагууд хэрхэн хариу арга хэмжээ авах, аврах ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар тодорхой зааж өгсөн бөгөөд энэ хуулиар эмнэлгийн болон аврах багуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, ослын үед мэдээллийг шуурхай солилцох, хохирогчдод түргэн хүрч ажиллах тогтолцоог бүрдүүлсэн. Бүгд Найрамдах Хятад ард Улс нь зам тээврийн осолд өртсөн хүмүүст тусламж үзүүлэх зорилгоор нийтийн тусламжийн сан байгуулсан.

Энэхүү сангийн хөрөнгө нь даатгалын шимтгэл болон бусад эх үүсвэрээс бүрддэг бөгөөд даатгалгүй эсвэл санхүүгийн боломжгүй иргэдийн эмчилгээний зардлыг нөхөн төлөх зориулалттай юм. Энэ нь ослын дараах санхүүгийн дарамтыг бууруулах, хүн бүрд тэгш тусламж хүргэхэд чиглэдэг.

**Япон Улс:** Зам тээврийн осол гарсан үед түргэн тусламж болон цагдаагийн байгууллага руу нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Осолд орсон иргэн, эсвэл гэрч болсон иргэн 119 (эмнэлэг, гал түймрийн) болон 110(цагдаа) руу залгаж мэдээлэлдэг. Тус улсад хэрэгждэг HELP system (Help system for Emergency Life saving and Public safety) гэх мэдээлэл дамжуулах дэвшилтэт системийн тусламжтайгаар ослын газрыг GPS болон камерын тусламжтайгаар автоматаар тогтоож, яаралтай тусламжийн баг очдог. Ослын газар дээр анхны тусламж үзүүлсний дараа хохирогчийг хамгийн ойрын эмнэлэгт хүргэж, цаашдын эмчилгээг үргэлжлүүлдэг. Осолд орсон иргэний эрүүл мэндийн зардлыг тухайн тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалаа нөхөн төлөхөөс гадна, хохирогч өөрийн эрүүл мэндийн даатгалаар дамжуулан нөхөн олговор авах боломжтой байхаар журам нь зохицуулагдсан байна.

**Холбооны Бүгд Найрамдах Герман Улс:** Тус улсад зам тээврийн ослын түргэн тусламжийг 112 дугаар утсаар дуудах бөгөөд тус улсын яаралтай тусламжийн тогтолцоо нь Европын хамгийн өндөр зохион байгуулалттай системийн нэг юм. Ослын газар аврах баг, эмчийн баг ирж, хохирогчид анхны тусламж үзүүлж, шаардлагатай тохиолдолд газар дээр нь амь насыг нь аварч болох мэс ажилбар, эмчилгээг хийдэг бөгөөд хохирогчдын зөвхөн ойролцоох эмнэлэгт бус тухайн гэмтэлд хамгийн тохиромжтой тусгайлсан эмнэлэг рүү хүргэх байдлаар зохион байгуулдаг ба зарим тохиолдолд нисдэг тэрэг ажиглана. Эмнэлгийн зардлыг жолоочийн хариуцлагатай даатгал, эсвэл төрийн нийгмийн даатгалын сангаас гаргадаг. Герман Улсын StVO буюу Замын хөдөлгөөний дүрмийн дагуу жолооч осол гаргасан тохиолдолд гэм буруутай эсэхээс үл хамааран хохирогчид тусламж үзүүлэх үүрэгтэй бөгөөд үүргээ биелүүлээгүй тохиолдолд эрүүгийн хариуцлагад татагддаг. Герман Улсад эмнэлгийн тусламж үзүүлэх нь төвлөрсөн болон мужийн хууль тогтоомжийн хослолоор зохицуулагддаг бөгөөд энэ нь улсынхаа эрүүл мэндийн үйлчилгээний тогтолцооны төвлөрөлгүй байдалд нийцдэг. Төв засгийн газар эрүүл мэндийн бодлогыг тогтоох бөгөөд 16 муж нь эрүүл мэндийн үйлчилгээ, яаралтай тусламжийн үйлчилгээ зэрэгтэй холбоотой тусгай хууль тогтоомжийг батлах эрхтэй байдаг. Яаралтай түргэн тусламж (EMS): Герман Улсад яаралтай тусламжийн үйлчилгээ нь ихэвчлэн мужийн түвшинд зохицуулагдана. Муж тус бүр нь Яаралтай түргэн тусламжийн хууль, зохион байгуулалтын бүтэцтэй бөгөөд энэ нь улс даяар үйлчилгээний гүйцэтгэлд ялгаатай байдал үүсгэдэг. Хууль эрх зүйн хүрээнд: Германы хуульд онцгой байдлын үед тусламж хэрэгтэй байгаа хүмүүст тусламж үзүүлэх үүрэгтэй гэж тодорхойлсон. Тусламж үзүүлээгүй тохиолдолд тус улсын Эрүүгийн хуульд заасан хуулийн дагуу хариуцлага хүлээхэд хүрнэ. Хамгийн чухал нь яаралтай тусламж үзүүлж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн эсвэл иргэн анхан шатны яаралтай тусламжийн стандартыг хангаагүй эсвэл нөхцөл байдлыг дордуулсан ч эрүүгийн хариуцлагад татагдахгүйгээр тус улсын хууль нь зохицуулагдсан байдаг. Хамтарсан холбоо G-BA : Энэхүү холбоо нь 2004 онд

байгуулагдсан бөгөөд эрүүл мэндийн тогтолцооны чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд эрүүл мэндийн хуулийн шинэчлэл болон шийдвэрүүдийг гаргах эрх бүхий хороо юм. Мөн энэ хороо нь эрүүл мэндийн яамнаас бие даан үйл ажиллагаа явуулдаг боловч холбооны зааврыг даатгалтай иргэд болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд заавал дагаж мөрдөх хуулийн зохицуулалттай юм.

**Оросын Холбооны Улс:** Оросын Холбооны Улсад Зам тээврийн ослын улмаас хохирогчдод эмнэлгийн тусламж үзүүлэх асуудлыг холбооны хууль, захиргааны хууль болон эрүүл мэндийн журам зэргийг хослуулан зохицуулдаг. Эдгээр хууль тогтоомжид ослын үед жолооч болон яаралтай тусламжийн баг болон эмнэлгийн байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхойлж өгдөг. Үүнд:

1.Эмнэлгийн яаралтай түргэн тусламж ОХУ-д яаралтай түргэн тусламжийг иргэншил болон даатгалын байдлаас үл хамааран хүн бүрд үнэ төлбөргүй үзүүлнэ. Яаралтай түргэн тусламжийг ихэвчлэн хот, бүс нутгийн засаг захиргаа, улсын яаралтай тусламжийн эмнэлгүүд эсвэл гамшгийн эмнэлгийн алба удирдан явуулдаг. ОХУ-ын Холбооны 323-ФЗ дугаар хуулийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах үндсэн зарчим”-ийн дагуу осол гэмтэл, болон амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй нөхцөл байдалд цагдаагийн алба хаагч, гал сөнөөгч, аврах багийн алба хаагчид заавал анхан шатны тусламж үзүүлнэ гэж заасан байдаг тул тэд маш сайн бэлтгэгдсэн боловсон хүчин байх шаардлагатай.

2.Хэргийн газрын жолоочийн үүрэг хариуцлага Зам тээврийн осол гаргасан жолооч ОХУ-ын Замын хөдөлгөөний дүрмийн дагуу дараах арга хэмжээг авна. Үүнд:

- а. Нэн даруй зогсож хэргийн газарт үлдэх
- б. Гэмтэл учирсан хүнд анхан шатны тусламж үзүүлэх
- в. Түргэн тусламж болон цагдаа дуудах

г. Эмнэлгийн баг цаг алдалгүй ирэх боломжгүй тохиолдолд хохирогчийг хамгийн ойрын эмнэлгийн байгууллагад хүргэн, ослын газар луу буцах Эдгээр үүргийг биелүүлээгүй тохиолдолд учруулсан гэмтлийн хүнд хөнгөнөөс хамааран захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээнэ.

3.Эмнэлгийн бүтэц болон даатгал ОХУ-д зам тээврийн болон бусад осол гэмтэлд өртсөн иргэдэд яаралтай түргэн тусламжаас гадна, нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх зорилгоор гэмтлийн эмнэлгийн холбоо сүлбээг сайжруулж байгаа. Хохирогчид буруутай этгээд буюу жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар эмчилгээний нөхөн төлбөр авах эрхтэй бөгөөд даатгалын дээд хэмжээ нь 500,000 рубль байдаг бөгөөд даатгалаас бүрэн нөхөн төлбөр өгч чадахгүй бол хохирогч иргэнийхээ хувиар ахин нэмэлт төлбөр тооцуулан авах боломжтой.

**Канад Улс:** Канад Улсад зам тээврийн осолд өртсөн иргэдэд эмнэлгийн тусламж үзүүлэх стандарт болон Канад Улсын Эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу яаралтай тусламж үзүүлдэг. Тус хууль нь эрүүл мэндийн тусламж үзүүлэх үндсэн зарчмууд тусгагдсан бөгөөд тээврийн хэрэгслийн осолд үзүүлэх тусламж гэсэн тодорхой нэршил заагдаагүй, нутаг дэвсгэрийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн стандартын дагуу тусламж үзүүлдэг байна. Эмнэлгийн яаралтай тусламж нь Канад Улсын даатгалтай үгүйгээс үл хамааран бүх хүнд тэгш хүртээмжтэй байдаг бөгөөд зам тээврийн ослын үеийн хохирогчдын яаралтай түргэн тусламжийн зардлыг ихэвчлэн мужийн эрүүл мэндийн даатгалаас хариуцдаг байна. Жишээлбэл Колумб,

Англи Улсад ослын нэмэгдэл тэтгэмж хөтөлбөр хэрэгждэг бөгөөд энэ хөтөлбөр нь тээврийн хэрэгслийн осолд холбогдсон хүн бүрд эмнэлгийн болон нөхөн сэргээх зардлыг даадаг байна. Тус улсад Зам тээврийн осолд өртсөн хохирогчид мужийн даатгалын тогтолцооноос хамааран янз бүрийн тэтгэмж авах боломжтой бөгөөд энэ тэтгэмж нь эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм, нөхөн сэргээх эмчилгээ зөвлөгөөний зардлыг нөхөн олгох зохицуулалттай юм. Жишээлбэл, Онтариа мужид Санхүүгийн үйлчилгээний зохицуулах газар (FSRA) байдаг бөгөөд энэ нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг хянаж, зөвхөн зам тээврийн ослоор гэмтэж бэртсэн иргэдийн эрүүл мэнд, нөхөн сэргээх зардлыг даатгалаар дамжуулан олгодог байна. Мөн энэ улсад тээврийн осолд өртсөн иргэдэд үзүүлэх тусламжийн төрлүүд болон тэдгээрийн хэрэгжилтийн журам муж, нутаг дэвсгэрээс шалтгаалан харилцан адилгүй байдаг.